

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн
2023 оны 04.. дугаар сарын 06..-ны өдрийн
15/368... дугаар албан бичгийн хавсралт

TT35150-#9092005

ҮЕРИЙН ДАРААХ ЗӨВЛӨМЖ

Нийслэл, аймаг орон нутагт үргэлжилсэн болон хүчтэй бороо орсны улмаас үер бууж эрүүл ахуй, стандартын шаардлага хангахгүй энгийн бие засах газар, бохирын цооногт байгаа өтгөн шингэн ялгадас, бохир ус, урсч хөрс, орчныг бохирдуулж байна. Энэхүү бохирлогдсон хөрс нь өвчин үүсгэгч бичил биетэн амьдарч үржих тохиромжтой орчин болдог бөгөөд цаашилбал хөрс, усыг бохирдуулж, улмаар хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үүсгэдэг.

Бохирлогдсон хөрсөнд халдварт өвчиний нян удаан хугацаагаар амьдарч халдварт өвчин гарах нөхцөлийг бүрдүүлдэг. Тухайлбал, Цусан суулга өвчиний үүсгэгч 2-4 сар, балнадын нян 3 сар, кокх хэлбэрийн нян 1-2 сар, үршдэг нян хэдэн арван жил амьдарч гэдэсний балнад, цусан суулга, сальмонеллэз, зооноз гельментүүдийн халдварт, халдварт шар өвчин дэгдэлт хэлбэрээр гардаг.

Иймд иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад дараах зөвлөмжийг өгч хэрэгжүүлнэ үү.
Үүнд:

- Ундны усыг баталгаат газраас авах, заавал буцалгаж хэрэглэх
- Ил задгай булаг шандны ус, гар худгийн усыг хүнсэнд хэрэглэхгүй байх
- Үерийн усаар бохирлогдсон хүнсний бүтээгдэхүүнийг шууд устгах
- Айл өрх, албан байгууллагууд үерийн улмаас үүсч тогтсон хог хаягдал, шавар шавхайг яаралтай цэвэрлэн зайлцуулах, халдварт гүйжүүлэлт хийлгүүлэх
- Үер болсон талбайд хүүхэд тоглуулахгүй байх, бага насны хүүхдүүдийг хараа хяналтгүй орхихгүй байх
- Аяга, таваг, хоолны хэрэгслийг зориулалтын угаагч бодисоор угаах, эсвэл 2%-ийн содын уусмалаар тогтмол угааж хэрэглэх, битүү шүүгээнд хадгалж, ялаа болон бусад шавж бохирдуулахаас сэргийлэх
- Хүн бүр хувийн ариун цэврийг сахих, гадуур явахдаа өмссөн гутал, гадуур хувцсаа солих, угааж цэвэрлэх
- Хоол хүнсийг заавал бүрэн болгож, буцалгаж хэрэглэх
- Шууд хэрэглэдэг жимс ногоог сайтар угаах, эсвэл хальсалж идэх
- Мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу энгийн бие засах газар, бохирын цооног, гадна талбайг халдварт гүйжүүлэх
- Хоол бэлтгэх, хоол идэхийн өмнө, бие зассаны дараа, хүүхэд гадаа тоглосны дараа болон бохирлогдсон тухай бүрт гарыг савандаж угаах
- Жорлон бохир усны цооногт ялаа, шавж авгалдайг зөвшөөрөгдсөн халдварт гүйтгэлийн бодисоор устгал хийх
- Халуурах, толгой өвдөх, хоолонд дургуй болох, бөөлжих, суулгах, булчин татах, ил шарх шалбархай үрэвсэх гэх мэт шинж тэмдэг илэрсэн тохиолдолд эмнэлэгт яаралтай хандах
- Эрүүл мэндийн байгууллагаас иргэдэд зориулсан мэдээлэл, зөвлөмжийг авах
- Эрүүл мэндийн болон Онцгой байдлын байгууллагаас халдварт өвчиний болзошгүй тохиолдлын үед хэрэглэх хүнс, халдварт гүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлэх
- Мэргэжлийн байгууллагаас нөөцийн хүнсний чанар, аюулгүй байдалд шинжилгээтэй хяналт хийж, халдварт гүйтгэлийн бодис идэвхийг тодорхойлсны үндсэн дээр

халдвартгүйжүүлэх үйл ажиллагаанд ашиглуулах, орон гэр нь үерт авсан хүмүүсийн хорогдох болон түр байршуулах байранд эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналт шалгалтыг тогтмол хийж, хүнс, ус болон орчны эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хангуулах

- Үерийн аюулд өртсөн бол бохирдсон хөрс, бие засах газар, бохир усны цооногт мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авч халдвартгүйжүүлэлт хийх.

Өргөн хэрэглээний халдвартгүйжүүлэлтийн бодис найруулах аргачлал

Гипохлорид:

600 мл гипохлорид натри эсвэл 10 гр гипохлорит кальцийг 10 л усанд хийж найруулна. Уусмалыг муу усны нүх, ил задгай бие засах газарт сайтар шингээж хийнэ. Хөрс болон гадна 1кв.м талбайд 1.5 л уусмал байхаар тооцож шүршинэ.

Жавелион:

10·л усанд 4 ширхэг шахмал хийн сайтар уусгана (0.06%). Уусмалыг муу усны нүх, ил задгай бие засах газарт сайтар шингээж хийнэ. Хөрс болон гадна талбайд 1кв.м талбайд 1.5 л уусмал байхаар тооцож шүршинэ.

Клорсепт:

10 л усанд 2 ширхэг шахмал хийн сайтар уусгана. Уусмалыг муу усны нүх, ил задгай бие засах газарт сайтар шингээж хийнэ. Хөрс болон гадна талбайд 1кв.м талбайд 1.5 л уусмал байхаар тооцож шүршинэ.

Тамир-Эм бэлдмэл:

1 л бэлдмэлийг ил задгай жорлон, бохирын цооногийн нэг булан руу асгаж хийнэ.

Эко-00 бэлдмэл:

Уутандаа 2 ширхэг ууттай бэлдмэл. Эхний уутыг задалж бүлээн 3-5 л усанд найруулан 30 минутын дараа жорлонд хийнэ. 7 хоногийн турш жорлонд хурумтлагдсан бохирыг далд ортол ус нэмж хийнэ. 7 хоногийн дараа 2 дахь уутыг дээрх аргаар дахин хэрэглэнэ. 3 долоо хоногийн турш жорлонг байнга устай байлгана.

Халуун үнс, модны үртэс:

Халдвартгүйжүүлэх бодис байхгүй тохиолдолд халуун үнс эсвэл модны үртсийг ил задгай жорлон, бохирын цооногт хийж болно.

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ